



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/34

Булган сум

Улсын төрөлжсөн олимпиадын II давааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II дугаар хуралдааны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадын II давааг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Улсын төрөлжсөн олимпиадын II давааг зохион байгуулахад шаардагдах 14,280,000 (арван дөрвөн сая хоёр зуун наян мянга) төгрөгийг “Шинэ Ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
01 дүгээр сарын 22-ны өдрийн А/ЗЧ дугаар
захирамжийн хавсралт

**2023-2024 ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН УЛСЫН ТӨРӨЛЖСӨН ОЛИМПИАДЫН
II ДАВААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ**

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Шагнал	-	-	-	11,780,000
2	Засагч, хянагч багшийн зардал	Тоо	100	20,000	2,000,000
3	Техник, технологийн олимпиадын хэрэглэгдэхүүний зардал	Тоо	25	20,000	500,000
			Нийт		14,280,000